# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр — Дугаар А/359 — Арвайхээр сум

## Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.5 дахь заалт, аймгийн Засаг даргын ‘’Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай’’ 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 дүгээр захирамжийн 3.1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмшигч байгууллагуудын ирүүлсэн санал, хөрөнгөнд үнэлгээ тогтоох комиссын дүгнэлтийн дагуу дуудлага худалдаагаар худалдах нэр бүхий 2 хөрөнгийг 1 дүгээр, үнэ тогтоож худалдах нэр бүхий 6 хөрөнгийг 2 дугаар, акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах нэр бүхий 1 хөрөнгийг 3 дугаар хавсралтаар тус тус батласугай.

2.Хөрөнгө худалдах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, акталсан тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Монгол улсын тээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэл мэдээллийн сангаас болон Татварын хэлтсийн бүртгэлээс хасуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг ‘’Хөрөнгө худалдсаны орлого’’ дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

6223 11 0694

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 07-ны өдрийн А/359 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

## ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ

| Д/д | Байгууллага, хөрөнгийн нэр | Улсын дугаар | Үйлдвэр-лэсэн он | Ашиглалтад орсон он | Арлын дугаар | Балансын үнэ | Хуримт-лагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Худалдах үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Онги Ус Суваг ОНӨААТҮГ-ын Гранд марк-2 маркийн автомашин | 86-16 ӨМҮ | 2003 | 2022 | GX1156011857 | 3,000,000 | 583,333.33 | 2,416,666.67 | 2,400,000 |
| 2 | Шүүхийн шийдвэрээр хураагдсан Исузу Бигхорн маркийн автомашин | 83-28 УБС | 1993 | - | UBS25GW7103187 | - | - | - | 3,000,000 |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 04-ны өдрийн А/359 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

## ҮНЭ ТОГТООЖ ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ

| Д/д | Байгууллага, хөрөнгийн нэр | Улсын дугаар | Үйлдвэр-лэсэн он | Ашиглалтад орсон он | Арлын дугаар | Балансын үнэ | Хуримт-лагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Худалдах үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уянга сумын Жаргалант багийн Эрүүл мэндийн төвийн УАЗ Пургон маркийн автомашин | 85-06 ӨВА | 2017 | 2017 | 220695H0403758 | 29,736,434 | 24,780,361.8 | 4,956,072 | 5,000,000 |
| 2 | Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн УАЗ Пургон маркийн автомашин | 59-53 ӨВА | 2017 | 2017 | 220695H0404010 | 29,736,434 | 24,780,388.80 | 4,956,045.20 | 5,000,000 |
| 3 | Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн ГАЗ 2410 | 55-59 ӨВА | 2003 | 2018 | 30570799 | 29,700,000 | 23,925,000 | 5,775,000 | 6,000,000 |
| 4 | Богд сумын Засаг даргын Тамгын газрын Микро автобус маркийн автомашин | 36-66 ӨВР | 2002 | 2019 | KMJRD37FP2K544931 | 12,000,000 | 4,666,666 | 7,333,333 | 3,000,000 |
| 5 | Шүүхийн шийдвэрээр хураагдсан Портер маркийн автомашин | 87-06 ӨВО | 2003 | - | KMFXKS7BP3U6648666 | - | - | - | 3,000,000 |
| 6 | Шүүхийн шийдвэрээр хураагдсан Портер маркийн автомашин | 31-96 ӨВР | 1997 | - | KMFXKS7BPVU129800 | - | - | - | 2,000,000 |

-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 07-ны өдрийн А/359 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

## АКТАЛЖ, ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД БОЛГОН ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ

| Д/д | Байгууллагын нэр, автомашины марк | Улсын дугаар | Ашиглал-тад орсон он | Үйлдвэр-лэсэн он | Арлын дугаар | Балансын үнэ | Хуримтлагд-сан элэгдэл | Үлдэх өртөг | Худалдах үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газрын Кама маркийн автомашин | 20-81 ӨВО | 2014 | 2014 | LWU2D21C6C KM00068 | 21,900,000 | 21,900,000 | - | 500,000 |

-оОо-